



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 11 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 320

Улаанбаатар
хот

Нүүрсний тээвэрлэлтийн талаар авах
зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нүүрсний тээвэрлэлтэд үүссэн хүндрэлтэй нөхцөл байдлыг арилгах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар нарт даалгасугай:

1.1. Гашуунсухайт-Ганц модны хилийн боомтын нэвтрүүлэх чадвар нэмэгдэх хүртэлх түр хугацаанд нүүрсний тээвэрлэлтийг Тавантолгойн нүүрсний ордоос Цагаан хадны гаалийн хяналтын бүс хүртэл, Цагаан хадны гаалийн хяналтын бүсээс Гашуунсухайт боомт хүртэл чиглэлээр тус тус зохион байгуулах;


1.2. Хилийн боомтоор нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн тоо хэмжээтэй уялдуулан нүүрсний ачилт, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд зохицуулалт хийж ажиллах.

2. Цагаан хадны гаалийн хяналтын бүс болон Гашуунсухайтын боомт хооронд нүүрсний тээвэрлэлт хийхдээ тус чиглэлийн орон нутгийн чанартай шороон зам ашиглах арга хэмжээ авч, гаалийн хяналтын бүсийн талбайд нүүрс буулгах, ачих үйл ажиллагааг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багатай байхаар зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар нарт даалгасугай.

3. Цагаан хадны гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

4. Гашуунсухайт боомтод орчин үеийн рентген аппарат, хяналтын тоног төхөөрөмж худалдан авах болон зохион байгуулалтын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Засгийн газрын нөөц сан болон бусад эх үүсвэрээс гаргах боломжийг судлан санал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгасугай.

5. Нүүрсний тээвэрлэлтийн болон гаалийн хяналтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчны талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа байдалд тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Н.Цагаанхүү, Өмнөговь аймгийн Засаг дарга Н.Наранбаатар нарт даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд

У.ХҮРЭЛСҮХ

Д.СУМЪЯАБАЗАР